



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/1907

Баруун-Урт сум

Барилга байгууламжийг байнгын
ашиглалтад
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.4 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Дүрэм шинэчлэн батлах дүрэм”-ийн нэгдүгээр хавсралтын 1 дүгээр заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Азийн Хөгжлийн Банкны захиран зарцуулах эрхтэй ядуурлыг бууруулах Япон сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Аймгийн төвүүдийн хатуу хог хаягдлын менежмент төслийн хүрээнд Баруун-Урт сумын төвд “Хог хаягдлын шинэ хяналттай ландфилл”-ын барилгын ажлыг байнгын ашиглалтад хүлээлгэж өгөх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Э.Төгөлдөр	- Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга
Комиссын нарийн бичиг:	Г.Баянжаргал	-Төслийн зохицуулагч
Гишүүд:	М.Нарантуяа	- Аймгуудын төвийн хатуу хог хаягдлын менежментийн төслийн барилгын хяналтын инженер (Захиалагчийн төлөөлөл)
	М.Одмандах	- Барилгын хяналтын инженер (Захиалагчийн төлөөлөл)
	М.Төртүвшин	- Барилга хөгжлийн төвийн хяналтын инженер
	Д.Отгонзул	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	Д.Наранцацралт	- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

М.Ганбаяр	байгуулалтын газрын мэргэжилтэн - Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газрын орлогч (ашиглагчийн төлөөлөл)
Ш.Энхманлай	-Эн Си Си Эс ХХК геотехникийн инженер (Зохиогчийн төлөөлөл)
Б.Дуламсүрэн	- Эн Си Си Эс ХХК Барилга бүтээцийн инженер
Ч.Цэцэн	- Эн Си Си Эс ХХК-ийн Архитектор
Х.Баатарсүх	- Сүхбаатар Аймаг Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дарга (Гүйцэтгэгчийн төлөөлөл)

2. Комиссыг бүрэн бүрэлдэхүүнээр хуралдуулж, холбогдох хууль, дүрэм, журам, тогтоомжийн хүрээнд барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг комиссын дарга (Э.Төгөлдөр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ